

“ХАРХОРИН” НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 04 дүгээр сарын 18 өдөр

Дугаар 01

Хархорин сум

Компанийн 2017 оны үйл ажиллагааны тухай
ТУЗ-аас гаргасан дүгнэлтийг батлах тухай

“Хархорин” Нээлттэй Хувьцаат Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2018 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9-г удирдлага болгон **ТОГТООХ** нь:

Компанийн 2017 оны жилийн үйл ажиллагааны талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хангалттай хэмээн үзсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Б.АМАРСАНАА

“ХАРХОРИН” НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 04 дүгээр сарын 18 өдөр

Дугаар 02

Хархорин сум

Компанийн 2017 оны санхүүгийн тайлантай
холбоотогоор ТУЗ-аас гаргасан дүгнэлтийг
батлах тухай

“Хархорин” Нээлттэй Хувьцаат Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2018 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9-г удирдлага болгон **ТОГТООХ** нь:

Компанийн 2017 оны жилийн санхүүгийн тайлангийн тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хангалттай хэмээн үзсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Б.АМАРСАНАА

“ХАРХОРИН” НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 04 дүгээр сарын 18 өдөр

Дугаар 03

Хархорин сум

2017 оны ногдол ашигтай холбогдуулан
ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг батлах тухай

“Хархорин” Нээлттэй Хувьцаат Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 01/2018 тоот тогтоол, Хувьцаа эзэмшигчдийн 2018 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн, Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.6-г удирдлага болгон ТОГТООХ нь:

“Хархорин” Нээлттэй Хувьцаат Компанийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн дагуух татварын дараах цэвэр ашгийн хэмжээ 33,599.7 мянган төгрөг байсан боловч компани нь 2017 оны ургац алдсан, үүнээс үүдэн компанийн санхүүгийн нөхцөл байдал хүнд, төлж барагдуулах шаардлагатай ихээхэн хэмжээний өр төлбөртэй байгаа, ногдол ашиг хуваарилсан тохиолдолд төлбөрийн чадваргүй болохоор байгаатай холбогдуулан 2017 онд ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан шийдвэрийг зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Б.АМАРСАНАА

“ХАРХОРИН” НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 04 дүгээр сарын 18 өдөр

Дугаар 04

Хархорин сум

Компанийн 2018 оны үйл ажиллагааны
төлөвлөгөөг батлах тухай

“Хархорин” Нээлттэй Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2018 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ нь:

1. “Хархорин” Нээлттэй Хувьцаат Компанийн 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
2. Төлөвлөгөөний биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.АМАРСАНАА